

# АНУ 2 АНАР



АДАЛ ЯВДАЛТ  
ЗУРАГТ НОМ



Хүсэл үү?  
Хэрэгцээ юу?



# Ану, Анар хоёртой танилцаарай

Нас: 14

Ам бүл: дөрөв (ээж, аав, эгч)

Хобби: дэлгүүр хэсэх

Дуртай хичээл: хими, математик, англи хэл

Мөрөөдөл: Ирээдүйд эмч мэргэжилтэй болох. Анартай танилцахаас өмнө ирэх жилийн мөрөөдлөө тодорхойлоогүй байсан.

Нас: 14

Ам бүл: тав (ээж, аав, дүү нар)

Хобби: зураг зурах, ном унших, содон зүйл турших

Дуртай хичээл: шугам зураг, геометр, англи хэл, биеийн тамир

Мөрөөдөл: Ирээдүйд барилгын инженер мэргэжилтэй болох. Ирэх жил хүүхдийн зусланд амарч үзэх.



Ану



Анар



Эгч

Учрал

Нас: 19, оюутан  
Хобби: дэлгүүр хэсэх, чамин эд зүйлс цуглуулах



Аав, ээж



Аав, ээж



# 9 дүгээр сарын 1

Манай ангийн  
шинэ сурагч.  
Танилц нэр нь Анар.



Ану, дэргэдээ  
Анарыг суулгаарай.



Танилцъя.  
Намайг Анар гэдэг.

Ану.



Чи энд юу хийж байгаа юм.  
Багш даалгавар өгөөгүй  
биз дээ?.

Тийм л дээ... Би дараа зун  
хүүхдийн зусланд амрах  
мөрөөдөлтэй болохоор  
төлөвлөгөө гаргах хэрэгтэй байна

### Анарын ирэх зуны мөрөөдөл

1. Зуслангийн төлбөр = 150 000 төгрөг
2. Сар бүр 15 000 төгрөг цуглуулах
3. Өдөр бүр 500 төгрөг хадгалах
4. 10 сарын дараа зуны зусланд амрах

Яагаад заавал мөнгө цуглуулах гэж?  
Аав, ээж хоёроосоо мөнгө аваад  
зуслан явдаг шүү дээ



Тийм л дээ. Гэхдээ...  
Орой болсон байна.  
Харьцгаах уу?

Бололгүй яахав. Харин чи миний  
асуултанд үнэн хариулаарай.

За тэгье. Гэхдээ чи намайг хүргэж өг.  
Харих замдаа яагаад мөнгө хадгалах гээд  
байгаа талаар чинь сонсмоор байна.



За тэг.

Чи мөнгөө хуримтлуулж  
мөрөөдлөө биелүүлж  
байсан уу?

Мөнгөө хуримтлуулахад  
яаж зөв зохион  
байгуулна гэдэг чинь...?

Би чамд өөрийнхөө  
туршлагаар  
тайлбарлаж өгье.




Өмнө нь би аав,  
ээжээсээ мөнгө  
аваад найзуудтайгаа  
PC тоглодог байлаа

Өнгөрсөн зун үеийн  
найзууд унадаг дугуйтай  
боллоо. Би бас дугуйтай  
болохыг үнэхээр  
хүсэж билээ.



Харин аав, ээж минь  
-Чи PC тоглосон мөнгөө  
цуглуулсан бол өөрийнхөө  
хүчээр унадаг дугуйтай  
болох байсан гэв.



Танай аав, ээж хоёр бусад  
хүүхдийн аав, ээжээс  
өөр юмаа.

Яг тийм. Тэр үед  
гэрийхэндээ их  
гомдож билээ.

PC  
GAME



Би сар болгон  
15000 ₮  
хуримтлуулсан.

Мөрөөдлийн хайрцаг" минь  
4 сарын хугацаанд  
60000 ₮-тэй болжээ.

Май миний хүү,  
"Мөрөөдлийн хайрцаг"-ны  
чинь урамшууллын  
хүү юм шүү.

Миний хүү  
тэвчээртэй байжээ.  
Мундаг байна.

РС тоглохоо больж мөнгөө  
хуримтлуулсан. Нэмээд  
аав, ээж 2 сар бүрийн эцэст  
10 хувийн хүүгийн урамшуулал  
үзүүлсэн.

Ингэж би 9 сарын турш  
мөрөөдлөө биелүүлэх  
хэмжээнд хүртэл мөнгөө  
хуримтлуулж, унадаг дугуйтай  
болсон шүү дээ.

Яаж тэр вэ?



Мундаг юмаа...  
Хүүе ямар хурдан  
гэрийнхээ үүдэнд  
ирэв ээ.

За, маргааш  
анги дээр уулзъя.  
Сайхан амраарай.

Тэгье.  
Сайхан амраарай.  
Хүргэж өгсөнд  
баярлалаа.





Гайхалтай.  
Би чамд туслахад бэлэн.  
Харин яаж?


Анар аа, би чам шиг мөнгөө  
хуримтлуулж мөрөөдлөө  
биелүүлэхээр шийдсэн.  
Чи надад туслах уу?



Тэгвэл эхлээд төлөвлөгөө  
гаргах хэрэгтэй. Харин чи  
төлөвлөгөөгөө биелүүлнэ шүү.

Би ч гэсэн чамтай адил  
зусланд амармаар байна.  
Гэхдээ өөрийнхөө хуримтлуулсан  
мөнгөөр шүү.

Тэгэлгүй яахав. хөёуулаа хичээлийн  
дараа номын санд сууж, миний  
төлөвлөгөөг хамт гаргацгаая.



Ану хичээл эрт тарсан  
юм чинь яаж  
дэлгүүр хэсэх үү?


За, тэгье охид оо.



Маргааш больё оо,  
Анар аа

Ану, чи төлөвлөсөн  
ажилтай шүү дээ.



Хичээлийн дараа





Чадалгүй дээ. Харин тэвчээртэй байхын тулд би юунаас эхлэх вэ? Надад зөвлөөч.

ТЭВЧЭЭР

Юу гэж Ану. Чи том мөрөөдөлдөө хүрэхийн тулд жижигхэн зориг, тэвчээр гаргаж чадах уу?

Найз нь чадахгүй ээ. Гэрийн даалгавараа хийх ёстой.

Анараа явж РС тогльё

Алив хурдан явж тогльё

Тэр үед чамд үнэхээр хэцүү байсан байх даа?

Тэр ч тийм шүү. Найзуудтайгаа уулзахаар РС хэрхэн гоё толгосон тухайгаа яриад л...

Би хүргэж өгөхүү?

Гэхдээ чи зориг, тэвчээр гаргаж, тэр бүхнийг давж чадсан шүү дээ. За найз нь харихаас...

Пөөх... тийм үү? Би заавал очноо.

Энэ удаад хэрэггүй дээ... Мартсанаас маргааш миний төрсөн өдөр хичээл тараад манайд ирээрэй.



Төрсөн өдрийн мэнд хүргэе. Үүнийг чамд

Хөөх... Миний мөрөөдлийн хайрцаг. Ямар гоё бэлэг вэ?



Баярлалаа. Ямар гоё харагдаж байна??? Би задаллаа шүү...



Эгч нь оюутан болохоор удахгүй сургуулиа төгсөөд аав, ээжээс авсан мөнгөө чамгаас түрүүлээд өгчихнэ. 3А


Аав, ээж надад 4000 ₮ өгөөрэй. Би ангийнхантайгаа кино үзнэ шүү.

Мхмм...

Охид минь мэтгэлцээд яах вэ. Өнөөдөр дүүгийнх нь төрсөн өдөр шүү дээ...

За тэгээрэй

Та 7 хоног бүр гадуур кино үзэх юм. Дэмий зүйлд их мөнгө үрээд байгаа юм шиг санагдахгүй байна уу?






Миний охины  
мөрөөдөл юу  
юм бэ?

Заавал яагаад мөнгөө  
хуримтлуулж зуслан явах гэж?  
Аав, ээж хоёр нь чамд мөнгө  
өгч болно шүү дээ.

Ухаантай охиноо  
дэмжилгүй  
ях вэ дээ....  
Ямар дэмжлэг  
хэрэгтэй байна?

Дараа зун өөрийнхөө  
тогмтол хуримтлуулсан  
мөнгөөрөө Анартай  
цуг зуслан явах болно.  
Та хоёр зөвшөөрөх үү?


Охин нь заавал  
мөрөөдөлдөө хүрэхийн  
тулд тэвчээртэй  
байх болно. Харин  
та хоёр  
намайг дэмжээрэй





Яриа дундуур нь зөвшөөрөлгүй оролцсонд уучлаарай. Ану өдөр бүр авч иддэг амттанаасаа татгалзаж, үүнд зарцуулдаг мөнгөө тогтмол цуглуулж, өмнөө тавьсан мөрөөдөлдөө өөрийн чадлаар хүрч чадна гэдгээ гэр бүл, найз нөхдийнхөө өмнө харуулахыг хүсч байгаа юм.


Миний охин хуримтлуулсан мөнгөнийхөө 10%-ийн хүүг аав ээжээсээ марталгүй авч байгаарай




•Мөрөөдлийн хайрцаганд минь цугласан мөнгөнд 10%-ийн хүү тооцож, урамшуулж байх Хагас, бүтэн сайн өдрүүдэд тогтмол 1000 төгрөг өгч байх, хуримтлуулсан мөнгөөрөө ирэх зун Анартай цуг зуслан явахыг минь зөвшөөрөх Зөвшөөрсөн Аав..... Ээж.....

Ээж нь хувьдаа зөвшөөрч байна. Ээж нь гарын үсгээ зурчихъя

Баярлалаа.  
Аав, ээж та  
хоёртоо хайртай  
шүү



Миний хэрэглэдэг зүйлсийн  
үнэ өдөр, өдрөөр өсч байхад би  
авдаг мөнгөө нэмүүлж болохгүй гэж үү?




Жишээ нь миний хэрэглэдэг  
уруулын будаг өнгөрсөн жил  
4000 төгрөг байсан бол одоо  
4500 төгрөгөөр авч байна.  
Дараа жил хэд ч болж өсөө билээ.  
Бүү мэд



Юмны үнэ өсч, буурч байдгийг миний эдийн засгийн ангид сурдаг оюутан охин маань арай мэддэггүй юм биш биздээ?

Хэрэв мөнгө нь дутвал ээж нь өгнөө.

Мэдээж шүү дээ



Мэдэлгүй дээ. Хэрэглэдэг зүйлсийн маань үнэ өсөхийг ерөнхийд нь Инфляци гэдэг. Хичээл дээрээ заалгасан юм.



Тэгвэл энэ жил 150000 төгрөгний үнэтэй байсан зуслангийн эрхийн бичгийн үнэ ирэх жил өсөх нь ээ?



Тийм шүү. Манай аав, ээж хоёр ч гэсэн тантай адилхан бодолтой байдаг.

Одоогоор миний найз нар дунд лав байхгүй л байна.

Сүүлийн үед юмны үнэ тогтворжиж байгаа болохоор миний хоёр хүү битгий санаа зовдоо. Хэрэв мөнгө нь дутвал аав нь биш ээж нь өгнө гэлээ шүү дээ.

Анараа, миний охинд зөв, сайнаар нөлөөлж байгаа чамд баярлалаа. Мөнгөө хуримтлуулж, мөрөөдлөө биелүүлдэг чам шиг хөвгүүд танай найз нар дунд олон бий биз?



Мөнгөө зөв зарцуулж байгаа хүүхдүүдээ дэмжилгүй яах юм.




Хүүхдүүд мөнгөө цуглуулж яах юм бэ?  
Би өдөр дэлгүүрт загвар  
сайтай, яг миний сонирхдог цамц  
өмсөж үзсэн. Тэрийг л авмаар байна.


Үгүй ээ... Тэр цамц зарагдчихвал  
яах юм бэ? Цорын ганц байгаа гэсэн



Аав нь цалин  
буухаар охиндоо  
авч өгье. Тэгэх үү?



Чи чинь саяхан ээжээрээ шинэ  
цамц авахуулсан биз дээ?  
Тэрийгээ ер өмсөж харагдахгүй юм.




Тэр цамцтай чинь яг адилханыг манай  
ангийн охин өмчихсөн байна билээ.  
Яаж би тэр охинтой адилхан цамц өмсөх юм бэ?

За яахав. Чи дүү шигээ  
тогтмол хуримтлал  
үүсгэж чадна гэвэл  
би тэр цамцыг нь авч өгье.  
Харин чадахгүй бол 3 сар  
шинэ хувцас худалдан  
авна гэж бүү санаарай.  
Болж байна уу?

Тэгье. Ёстой амархан. Би ер нь  
банкинд хадгаламжтай болъё  
гэж аль эртнээс бодоод байсан юм.  
Тэгээд мөнгөө хийгээд л гүйцээ.

Эгч минь одоо бодоод  
байлгүй хамтдаа хэрэгжүүлье.





Ирсэнд баярллаа  
бас гоё бэлэг өгсөнд...

Би харьж гэрийн даалгавраа хийгээд, дүү нараа цэцэрлэгээс нь авах ёстой. Сайхан хоол, амттанаар дайлсан та бүхэнд баярлалаа



Төрсөн өдөрөөс  
хойш нэг сарын дараа

Өөрийн хуримтлуулсан 30000 ₮, аав ээж хоёр өмнөх сарын хүүг тооцож өгсөн. Нийт 31500₮

Чиний мөрөөдлийн хайрцагт хэдэн төгрөг хуримтлагдсан бэ? Тоолсон уу?

Хөөх... Чи өдөр бүр хуримтлуулж чаджээ. Маш сайн байна.

Анар аа миний мөрөөдлийн хайрцагт хэдэн төгрөг хуримтлагдсан гээч, чи лав итгэхгүйдээ...





Тоогүй юм  
болж дээ

Нээрээ, Учрал эгч бас чам шиг  
15000 төгрөгтэй болсон  
байх ёстой бил үү?

Уг нь тийм л дээ. Гэхдээ эгч маань  
2 хоног цуглууд хүсэлдээ  
дийлдээд мөнгөө үрчихсэн

Мхмм...



Нээрээ тийм шүү. Би үүнийг хийж чадаж байна гэж өөрөөрөө бахрах сэтгэл бас төрдөг юм.

Би ч эхэндээ шантарч байсан шүү.

Ер нь эхлэл нь хэцүү байдаг юм. Гэхдээ мөнгөтэй мөрөөдлийн хайрцагаа дахин дахин харахаар урамшаад байдаг шүү.

Ер нь хүүхдүүд бид битгий хэл зарим, томчууд цалингаасаа хуримтлал үүсгэж чаддаггүй гэсэн.

Тийм үү.



Хоёулаа явж амттан авч идэх үү? Би чамайг дайльъя.




Ямар гоё юм бэ? Өнөөдөр ямар нэг онцгой өдөр биш биз?



Өнөөдөр чиний хувьд нэг сарын турш зориг, тэвчээр гаргаж чадсан амжилтын өдөр шүү дээ.

Нээрээ тийм байна. Явж тэмдэглэе. Би жимстэй бялуу идмээр байна. Ямар гоё вэ?



Зуны амралт  
эхэллээ, Ура..



Зуслан явах  
мөрөөдөл  
маань ойртсоор...

Тэгье, тэгье. Долдугаар  
сарын эхээр хамтдаа  
бэлдэж эхлэх үү.

Хоёулаа  
зуслангийн  
бэлтгэлээ  
хамтдаа  
хийх үү?



Энэ жилийн зуслангийн эрхийн бичгийн үнэ битгий нэмэгдчихсэн байгаасай.

Харин тийм ээ... Гэхдээ хоёуланд нь мөнгө дутвал ээж дэмжлэг үзүүлнэ гэж амласан шүү дээ. Санаж байгаа биз.

Мхмм...



Би лав санаа зовохгүй байна. Миний мөрөөдлийн хайрцагт хуримтлагдсан мөнгө хангалттай хүрнэ гэж бодож байна

Тийм дээ, хоёулаа хуримтлал үүсгэж чадсан юм чинь юундаа ч санаа зовох юм бэ дээ.



Авч явах зүйлс чинь бүрэн биз?  
Дахиж сайн нягтлаарай За, за бүрэн байгаа.  
Санаа зоволтгүй дээ. 7:30-д уулзацгаая. Түр баяртай.

Чи яаж унтаж чадаж байнаа?  
Би лав 10 сар хүлээсэн  
мөрөөдөл минь өнөөдөр биелнэ  
гэж бодохоор нойр хүрсэнгүй.

Байна уу Ану, сэрсэн үү?

Хэхэ... Ямар  
их догдлол вэ?  
Тайван байл даа.

Ммм... Ямар эрт залгаж  
байнаа. Сая сэргээ.

Би ч гэсэн энэ хоёр шиг мөнгөө  
хуримтлуулж чадах юм чинь.  
Харин яаж эхлэх вэ байх???

Аав, ээж нараа амрах  
хугацаанд эргэж ирээрэй.

Сайхан амраад олон найз,  
нөхөдтэй болоод ирээрэй,  
хүүхдүүдээ. Гол, уснаас хол  
байгаарай. Наршиж,  
даарваа, Сайн яваарай  
хүүхдүүдээ.

ЗУСЛАНГИЙН АВТОБУС